


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2017 оны эхний 7 сарын байдлаар 3,899.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 4,488.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 589.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээний 29.2 хувьтай тэнцэж, төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад буурч сайжирлаа.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/



Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 848.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 143.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсөв 115.2 тэрбум төгрөгийн тус тус ашигтай гарсан байна.

2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 28.3 хувь буюу 859.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, харин нийт зарлага 10.5 хувь буюу 525.4 тэрбум төгрөгөөр бага зарцуулагдсан байна. Орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 38.7 пунктээр өндөр байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 70.1 хувь буюу 1,384.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарлаа.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	493.1	1,149.9	256.8	22.3	893.1
Засгийн газрын бонд	1,164.3	119.0	381.7	320.7	-262.7
Засгийн газрын зээл	316.7	255.7	-132.9	-52.0	388.5
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	80.3	83.0	103.4	-2.7
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	408.0	0.0	-	408.0
Өмч хувьчлал	0.0	7.5	0.8	10.3	6.8
НИЙТ ДҮН	1,974.1	2,020.4	589.4	29.2	1,424.3

Эх сурвалж: Сангийн яам

2017 оны эхний 7 сард гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 87.8 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бонд, векселийн үндсэн төлбөрт 2,155.9 тэрбум төгрөгийг тус тус төлж, 421.4 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авчээ. Засгийн газрын 1,085.8 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 1,260.3 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод бонд, мөн 1,498.2 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад бондыг тус тус арилжаалсан байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,899.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28.3 хувь буюу 859.3 тэрбум төгрөгөөр өсч, мөн орлогын төлөвлөгөө 8.1 хувь буюу 293.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 6.3 хувь буюу 163.7 тэрбум төгрөгөөр орон нутгийн төсөв 1.3 хувь буюу 17.1 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын төсөв 8.3 хувь буюу 89.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 794.0 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 129.9 тэрбум төгрөгөөр нийгмийн даатгалын сангийн орлого 203.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 2. /тэрбум төгрөг/


Ангилал	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,942.5	4,274.5	2,953.1	3,155.1	1,329.6	1,346.8	1,083.3	1,172.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	135.4	156.2	135.4	156.2	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	201.2	218.9	201.2	218.9	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,605.9	3,899.5	2,616.4	2,780.1	1,329.6	1,346.8	1,083.3	1,172.7
Татварын орлого	2,925.9	3,362.5	1,827.4	2,151.4	490.1	502.3	740.7	830.1
Орлогын албан татвар	719.3	881.8	414.5	573.0	304.8	308.8	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	608.3	708.7	0.0	0.0	0.0	0.0	740.7	830.1
Хөрөнгийн албан татвар	70.0	71.4	0.0	0.0	70.0	71.4	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	723.3	856.0	723.3	856.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	277.0	245.9	277.0	245.9	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	5.7	6.7	5.7	6.7	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	225.8	263.8	225.8	263.8	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	296.4	328.2	181.1	206.1	115.3	122.2	0.0	0.0
Татварын бус орлого	680.0	537.0	789.0	628.7	839.5	844.4	342.6	342.6
Нийтлэг татварын бус орлого	570.4	520.1	486.3	431.1	84.1	89.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.3	0.4	0.0	0.0	0.3	0.4	0.0	0.0
Тусламжийн орлого	109.3	16.5	219.0	121.2	0.1	0.0	342.6	342.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	83.7	76.3	755.0	755.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 86.2 хувийг татварын орлого, 13.8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 26.4 хувь буюу 701.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 41.6 хувь буюу 157.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Татварын орлого 2,302.0 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 14.9 хувь буюу 436.7 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 26.2 хувийг орлогын албан татвар, 25.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 21.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.3 хувийг онцгой албан татвар, 7.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 2.1 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 9.8 хувийг бусад татвар бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/




Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн орлогын албан татвар 22.6 хувь /162.5 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 16.5 хувь /100.4 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 18.3 хувь /132.7 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 16.7 хувь /1.0 тэрбум.төг/, гадаад худалдааны орлого 16.8 хувь /38.0 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 2.0 хувь /1.4 тэрбум.төг/, бусад татвар 10.7 хувь /31.9 тэрбум.төг/-иар тус тус давж биелжээ. Харин онцгой албан татвар 11.2 хувь буюу 31.1 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Татварын орлого өмнөх оны мөн үеэс 701.5 тэрбум төгрөг буюу 26.4 хувиар өссөн байна. Онцгой албан татвар 88.0 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч орлогын албан татвар 305.1 тэрбум (52.9%), нэмэгдсэн өртгийн албан татвар 260.4 тэрбум (43.7%), бусад татвар 48.0 тэрбум (17.1%), гадаад үйл ажиллагааны орлого 103.2 тэрбум (64.2%), нийгмийн даатгалын орлого 63.9 тэрбум (9.9%), хөрөнгийн албан татвар 7.3 тэрбум (11.5%) болон тусгай зориулалтын орлого 1.6 тэрбум төгрөг (30.7%)-өөр тус тус нэмэгдсэн нь татварын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

Татварын бус орлого 537.0 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 41.6 хувь буюу 157.8 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч орлогын төлөвлөгөө 21.0 хувь буюу 143.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө дутуу биелэхэд гадаад хандив, тусламжийн орлого 92.9 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 42.1 тэрбум, газрын тосны орлого 28.1 тэрбум, навигацийн орлого 12.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нөлөөлжээ. Харин хүүгийн орлого 3.7 тэрбум, торгуулийн орлого 2.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Татварын бус орлогын 96.9 хувийг нийтлэг татварын бус орлого, 3.1 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна. Нийтлэг татварын бус орлогын 43.1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 21.6 хувийг газрын тосны орлого, 13.7 хувийг навигацийн орлого, 2.5 хувийг хүүгийн орлого, 4.3 хувийг торгуулийн орлого, 8.3 хувийг бусад орлого эзэлж байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн дагуу 20 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 5 нь орлогын төлөвлөгөөгөө биелүүлж, 15 нь 0.6-100.0 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

2017 оны эхний 7 сард улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн сайд	2,197,665.0	3,666,348.2	2,600,567.9	1,065,780.4	70.9
Татварын ерөнхий газар	1,566,785.9	2,072,115.0	1,570,581.5	501,533.4	75.8
Гаалийн ерөнхий газар		913,243.6	998,049.4	-84,805.8	109.3
Сангийн яам	23,314.9	609,824.7	29,079.1	580,745.7	4.8

Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	579,173.0	39,458.7	-5,677.5	45,136.2	(14.4)
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	25,429.8	29,770.2	1,344.3	28,426.0	4.5
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,961.4	1,936.0	7,191.1	-5,255.2	371.5
Монгол Улсын Их Хурлын дарга	761.5	1,580.7	1,120.8	459.9	70.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	761.5	1,580.7	1,120.8	459.9	70.9
Монгол Улсын Ерөнхий аудитор	0.0	332.8	0.0	332.8	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	332.8	0.0	332.8	-
Монгол Улсын Ерөнхий сайд	2,122.4	17,817.7	12,457.0	5,360.8	69.9
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	0.0	1,150.0	0.0	1,150.0	-
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	0.0	14,633.4	9,342.5	5,290.9	63.8
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,122.4	2,034.3	3,114.4	-1,080.1	153.1
Монгол Улсын Шадар сайд	9,912.5	6,908.7	7,566.9	-658.2	109.5
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	342.5	1,351.8	2,064.3	-712.6	152.7
Стандарт, хэмжил зүйн газар	352.1	1,324.8	1,549.5	-224.7	117.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	4,212.2	4,063.5	953.6	3,109.9	23.5
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,005.6	168.6	2,999.5	-2,830.9	1,778.9
Хууль зүй, дотоод хэргийн сайд	18,293.0	23,347.3	23,205.0	142.3	99.4
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	9,129.1	9,275.0	11,728.0	-2,453.0	126.4
Цагдаагийн ерөнхий газар	0.0	2,034.4	1,182.4	851.9	58.1
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	0.0	0.0	0.0	0.0	-
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	463.8	2,070.5	1,870.3	200.1	90.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	8,700.1	9,967.4	8,424.3	1,543.1	84.5
Гадаад харилцааны сайд	2,543.8	8,324.0	11,738.6	-3,414.7	141.0
Дипломат төлөөлөгчийн газрууд	2,226.3	7,419.8	11,444.0	-4,024.2	154.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	317.5	904.2	294.6	609.6	32.6
Зам, тээврийн хөгжлийн сайд	40,713.6	89,378.9	76,328.7	13,050.2	85.4
Иргэний нисэхийн ерөнхий газар	38,000.0	83,608.6	71,310.8	12,297.8	85.3
Зам, тээврийн хөгжлийн яам	20.0	110.5	110.5	0.0	100.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	217.4	4,551.1	703.1	3,848.0	15.4
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,476.3	1,108.7	4,204.3	-3,095.6	379.2
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	86,698.0	192,593.9	151,368.1	41,225.8	78.6
Ашигт малтмал, газрын тосны газар	85,518.7	186,186.0	145,059.3	41,126.7	77.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		2,905.8	0.0	2,905.8	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,179.3	3,502.1	6,308.8	-2,806.7	180.1
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	853.5	67,089.6	34,995.1	32,094.5	52.2
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	215.0	0.0	215.0	-
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	220.1	307.5	246.6	60.9	80.2
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	9,697.0	0.0	9,697.0	-

Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	633.4	56,870.1	34,748.5	22,121.5	61.1
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	20,086.0	136,037.3	101,153.9	34,883.4	74.4
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	593.0	42,595.6	35,070.0	7,525.6	82.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	13,621.2	6,298.7	5,308.9	989.8	84.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,871.8	87,143.0	60,775.0	26,368.0	69.7
Эрүүл мэндийн сайд	97,349.5	122,232.6	113,947.3	8,285.3	93.2
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	85,563.2	104,736.5	100,091.1	4,645.5	95.6
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	548.5	3,073.8	940.4	2,133.3	30.6
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	11,237.8	14,422.3	12,915.8	1,506.5	89.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	5,268.3	17,313.5	5,854.6	11,458.9	33.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,979.5	17,131.6	5,569.6	11,562.0	32.5
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	2,288.8	182.0	285.0	-103.1	156.6
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	87.7	615.5	78.1	537.5	12.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	532.4	0.0	532.4	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	87.7	83.1	78.1	5.1	93.9
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	3,732.1	27,778.6	3,988.6	23,790.0	14.4
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	24,895.6	402.8	24,492.8	1.6
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,732.1	2,883.1	3,585.8	-702.8	124.4
Барилга, хот байгуулалтын сайд	0.0	1,726.8	694.3	1,032.4	40.2
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	0.0	907.4	694.3	213.0	76.5
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	819.4	0.0	819.4	-
Батлан хамгаалахын сайд	28,772.4	32,631.3	44,874.4	-12,243.1	137.5
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	2,405.3	2,697.0	2,596.4	100.6	96.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	26,367.2	29,934.3	42,278.0	-12,343.7	141.2
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	31.4	24.6	106.6	-82.0	433.7
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	31.4	24.6	106.6	-82.0	433.7
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	813.4	479.7	479.7	0.0	100.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	813.4	479.7	479.7	0.0	100.0
Үндэсний статистикийн хорооны дарга	0.0	373.0	2.7	370.4	0.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	369.5	0.0	369.5	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	3.5	2.7	0.8	75.8

Эх сурвалж: Сангийн яам

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 5,626.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 79.8 хувийг ашиглаж, 1,137.4 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 4. /тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,626.3	4,488.9	4,273.8	3,628.1	1,670.0	1,203.3	1,106.0	1,057.6
НИЙТ ЗАРЛАГА	5,443.9	4,379.5	4,114.5	3,528.1	1,646.8	1,193.9	1,106.0	1,057.6
УРСГАЛ ЗАРДАЛ	4,343.0	3,814.3	3,417.5	3,060.9	1,243.0	1,095.9	1,106.0	1,057.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,017.3	1,690.2	1,240.4	1,005.6	863.7	767.0	11.4	10.5
Зээлийн үйлчилгээний төлбөр	646.9	583.3	646.9	583.3	0.0	0.0	0.0	0.0
Татаас	182.9	148.0	411.7	405.7	50.6	43.4	63.1	41.4
Урсгал шилжүүлэг	1,495.9	1,392.7	1,118.4	1,066.3	328.7	285.5	1,031.5	1,005.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,100.9	565.2	697.0	467.1	403.9	98.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	182.4	109.4	159.2	100.0	23.1	9.4	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-2,020.4	-589.4	-1,657.4	-848.0	-340.3	143.5	-22.7	115.2

Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 645.7 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 466.7 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 48.5 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна. Улсын төсвийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 205.1 тэрбум, орон нутгийн төсвийн зардал 59.4 тэрбум төгрөгөөр тус тус буурч, харин нийгмийн даатгалын сангийн зардал 91.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 10.5 хувь буюу 525.4 тэрбум төгрөгөөр буурахад эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 489.3 тэрбум, хөрөнгийн зардал 19.5 хувь буюу 136.6 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Харин урсгал зардал 100.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд зээлийн үйлчилгээний төлбөр 179.9 тэрбум, урсгал шилжүүлэг 59.2 тэрбум, татаас 27.9 тэрбум төгрөгөөр өсч харин бараа, ажил үйлчилгээний зардал 166.6 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/Зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5. /тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Ху в ь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,014.3	5,626.3	4,488.9	79.8	1,137.4
НИЙТ ЗАРЛАГА	4,415.6	5,443.9	4,379.5	80.4	1,064.5
УРСГАЛ ЗАРДАЛ	3,713.8	4,343.0	3,814.3	87.8	528.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,856.7	2,017.3	1,690.2	83.8	327.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,015.7	1,073.1	1,040.6	97.0	32.5

Үндсэн цалин	897.0	875.9	865.9	98.9	10.0
Нэмэгдэл	47.7	114.8	102.3	89.1	12.5
Унаа хоолны хөнгөлөлт	19.4	23.6	20.9	88.6	2.7
Урамшуулал	27.3	32.2	28.6	88.7	3.6
Гэрээт ажлын хөлс	24.3	26.6	22.9	86.2	3.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92.5	98.2	92.9	94.6	5.3
Тэтгэврийн даатгал	92.5	60.9	57.6	94.6	3.3
Тэтгэмжийн даатгал	0.0	7.7	7.3	94.4	0.4
ҮОМШӨ-ний даатгал	0.0	7.2	6.8	94.8	0.4
Ажилгүйдлийн даатгал	0.0	1.7	1.6	94.6	0.1
Эрүүл мэндийн даатгал	0.0	20.8	19.6	94.5	1.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120.7	143.4	123.0	85.8	20.4
Гэрэл, цахилгаан	23.6	27.1	23.9	88.3	3.2
Түлш, халаалт	76.2	89.4	75.6	84.6	13.7
Цэвэр, бохир ус	11.2	14.1	11.5	81.6	2.6
Байрны түрээс	9.6	12.9	11.9	92.6	1.0
Хангамж, бараа материалын зардал	64.7	74.5	60.1	80.7	14.4
Бичиг хэрэг	4.9	6.0	5.1	84.8	0.9
Тээвэр, шатахуун	24.4	25.2	22.4	89.0	2.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.5	7.2	6.0	83.2	1.2
Ном, хэвлэл	1.6	4.6	0.8	17.2	3.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22.8	26.1	21.5	82.4	4.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.5	5.4	4.3	79.3	1.1
Нормативт зардал	131.9	151.9	124.6	82.0	27.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56.3	69.2	57.7	83.4	11.5
Хоол, хүнс	54.3	60.1	51.2	85.1	8.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	21.4	22.5	15.7	69.7	6.8
Эд хогшил, урсгал засварын зардал	23.5	35.2	26.8	76.3	8.4
Багаж, техник, хэрэгсэл	6.3	11.5	8.5	73.8	3.0
Тавилга	2.6	1.3	1.1	85.9	0.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.4	0.8	0.4	55.5	0.4
Урсгал засвар	14.2	21.6	16.8	77.8	4.8
Томилолт, зочны зардал	10.1	14.0	10.5	75.0	3.5
Гадаад албан томилолт	3.1	4.6	4.0	86.5	0.6
Дотоод албан томилолт	5.7	7.9	5.3	67.9	2.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	1.3	1.5	1.2	76.5	0.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185.1	316.3	159.7	50.5	156.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155.7	290.8	143.3	49.3	147.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.7	1.0	0.6	63.0	0.4
Даатгалын үйлчилгээ	5.4	8.0	7.0	87.0	1.0
Тээврийн хэрэгслийн татвар	0.5	0.6	0.4	73.5	0.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.1	73.9	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2.5	5.6	3.2	56.1	2.5
Газрын төлбөр	0.5	1.0	0.6	66.9	0.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.3	1.0	0.7	68.7	0.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4.3	8.1	3.8	47.3	4.3
Бараа үйлчилгээний бусад зардал	305.1	209.0	144.8	69.3	64.2
Бараа үйлчилгээний бусад зардал	290.4	186.4	126.9	68.1	59.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14.7	22.7	17.9	79.1	4.7
ХҮҮ	403.4	646.9	583.3	90.2	63.6
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	160.9	309.5	271.0	87.6	38.5

Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	242.5	337.4	312.3	92.6	25.1
ТАТААС	120.1	182.9	148.0	80.9	34.9
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	8.4	14.9	13.2	88.7	1.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	111.8	168.0	134.8	80.3	33.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,333.6	1,495.9	1,392.7	93.1	103.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	36.3	11.0	12.1	109.7	-1.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	29.9	6.8	9.3	135.9	-2.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	6.3	4.2	2.8	66.9	1.4
Бусад урсгал шилжүүлэг	1,297.3	1,484.8	1,380.7	93.0	104.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	831.2	921.7	901.0	97.8	20.7
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	305.8	329.8	308.7	93.6	21.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5.3	4.0	2.6	65.8	1.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101.2	120.7	83.2	68.9	37.6
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43.6	59.4	40.1	67.4	19.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7.2	45.3	42.2	93.3	3.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2.9	3.9	2.9	73.8	1.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	701.8	1,100.9	565.2	51.3	535.7
Барилга байгууламж	439.7	785.1	447.5	57.0	337.6
Их засвар	72.4	39.4	16.7	42.2	22.8
Тоног төхөөрөмж	16.9	75.6	29.0	38.3	46.6
Бусад хөрөнгө	60.5	176.6	52.5	29.7	124.1
Стратегийн нөөц хөрөнгө	1.5	24.1	19.5	80.9	4.6
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	110.7	0.0	0.0	-	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	598.6	182.4	109.4	60.0	73.0
Эргэж төлөгдөх зээл	584.7	146.4	67.4	46.0	79.0
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	-	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	14.0	36.0	42.0	116.8	-6.0


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 85.0 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 10.9 пунктээр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 85.0 хувь буюу 3,814.3 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 44.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 15.0 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.0 хувийг татаас, 37.0 хувийг урсгал шилжүүлэг бүрдүүлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 100.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд зээлийн үйлчилгээний төлбөр 179.9 тэрбум, татаас 27.9 тэрбум, урсгал шилжүүлэг 59.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах эрхийг баталсан бөгөөд улсын төсвийн 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 586.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Улсын төсвийн нийт зарлагын 21.8 хувийг Сангийн сайдын багц, 18.6 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 9.7 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 18.4 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.8 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 2.9 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, 10.2 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайд, 2.6 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, үлдэх 8.9 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	2,879.4	2,460.1	419.4	85.4
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	17,692.4	15,099.3	2,593.2	85.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	102,263.4	45,162.4	57,101.0	44.2
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	12,382.8	7,368.4	5,014.4	59.5
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	39,569.9	37,147.0	2,422.9	93.9
САНГИЙН САЙД	900,640.2	768,692.0	131,948.2	85.3
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	127,678.7	102,881.9	24,796.8	80.6
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	396,557.4	341,981.6	54,575.8	86.2
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1,071.5	908.2	163.3	84.8
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	2,744.2	2,108.1	636.1	76.8
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	28,983.2	26,847.3	2,135.9	92.6
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	16,073.4	15,140.5	932.9	94.2
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1,218.9	1,154.6	64.3	94.7
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	5,791.5	4,965.0	826.4	85.7
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	4,584.1	3,470.9	1,113.2	75.7
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1,609.8	1,503.5	106.4	93.4
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	512.5	503.8	8.8	98.3
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	351.1	295.2	56.0	84.1
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	71,436.0	53,597.9	17,838.1	75.0
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	15,436.3	15,014.8	421.5	97.3
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	494.9	418.5	76.4	84.6
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	6,506.6	4,777.6	1,729.0	73.4
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	49,606.5	27,967.9	21,638.6	56.4
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	286,736.6	240,450.5	46,286.1	83.9
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	44,058.3	16,358.4	27,699.9	37.1
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	786,029.9	656,475.2	129,554.6	83.5
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	299,199.7	361,525.3	-62,325.7	120.8
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	16,061.7	7,992.3	8,069.4	49.8
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	118,616.4	92,711.5	25,904.9	78.2
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	51,715.0	23,224.2	28,490.8	44.9
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	706,032.6	649,869.3	56,163.4	92.0
НИЙТ ЗАРДАЛ	4,114,534.9	3,528,073.1	586,461.8	85.7

Эх сурвалж: Сангийн яам

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 120.3 тэрбум төгрөг зарцуулж, 41.4 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 оны эхний 7 сард хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 290.8 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 120.3 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 170.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

График 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөгөөр/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл, /төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Хүснэгт 7.

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	2017 оны эхний 7 сарын гүйцэтгэл				
		Төсөв	Төлөв.	Гүйцэт.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,688.0	1,688.0	1,688.0	1,634.4	53.6	96.8
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	8,100.0	2,778.0	2,200.0	0.0	2,200.0	0.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	45,243.4	5,287.3	5,287.3	2,934.7	2,352.6	55.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	15,348.3	3,857.9	2,354.6	826.9	1,527.7	35.1
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2,593.5	824.3	824.3	156.4	667.9	19.0
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	5,160.0	700.0	700.0	437.6	262.4	62.5
САНГИЙН САЙД	43,477.8	10,481.7	8,609.2	1,224.4	7,384.8	14.2
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	67,530.2	27,663.2	26,506.1	14,168.8	12,337.3	53.5
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	24,234.7	7,679.1	5,441.0	2,092.6	3,348.4	38.5
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	30,296.8	2,693.1	1,925.7	700.2	1,225.5	36.4
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	484,012.4	81,294.1	35,322.9	9,195.3	26,127.5	26.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	415,256.9	104,136.2	63,814.1	12,926.7	50,887.4	20.3
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	791,113.4	133,982.5	65,145.5	42,985.7	22,159.8	66.0
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	52,066.3	26,984.6	10,776.3	2,027.9	8,748.4	18.8
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	185,504.5	49,422.1	34,066.0	24,305.4	9,760.6	71.3
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	181,431.3	32,439.0	25,172.7	3,795.7	21,377.0	15.1
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	1,031.4	851.4	851.4	768.9	82.5	90.3
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	952.7	88.3	88.3	88.3	0.0	100.0
НИЙТ ДҮН	2,355,041.6	492,850.8	290,773.4	120,270.1	170,503.3	41.4


Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид эхний 7 сард 36.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 30.9 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 5.5 тэрбум төгрөгөөр дутуу буюу 84.9 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

5. Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого:

График 7. Нийгмийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөгөөр/




Нийгмийн даатгалын санд 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нийт 1,172.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 8.3 хувь буюу 89.4 тэрбум төгрөгөөр давж биелэн, орлогын гүйцэтгэл 108.3 хувьтай гарчээ.

Нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 203.2 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар өссөн байна. Тус санд улсын төсвөөс 342.6 тэрбум төгрөгийн татаас олгожээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг дараахь байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын санд 837.7 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын санд 58.8 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 74.3 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын санд 24.9 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 198.7 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага:

График 8. Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/




2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн нийт зардалд 1,016.0 тэрбум төгрөг төлөвлөснөөс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бусад зардалд нийт 1,057.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 95.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 48.5 тэрбум төгрөгийн хэмнэлт гарчээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн нийт зардал 91.6 тэрбум төгрөгөөр буюу 9.5 хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2017 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 11.5 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 14.7 хувь, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 42.0 хувь, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 26.9 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 2.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

График 9. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /хувиар/



2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 836.8 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 53.0 тэрбум төгрөг, YOMШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 24.7 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид болон бусад зардалд 21.2 тэрбум төгрөг, эрүүл мэндийн

даатгалын сангаас эмнэлэгийн тусламж, үйлчилгээ, рашаан сувилал, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад зардалд 148.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн зарлага 466.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.


2017 оны эхний 7 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого 1,346.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 1.3 хувь буюу 17.1 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, нийт зарлага 1,203.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 27.9 хувь буюу 466.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 10.7 хувь буюу 129.9 тэрбум төгрөгөөр өсч, харин нийт зарлага 4.7 хувь буюу 59.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 43.9 хувийг орон нутгийн төсвийн орлого, 6.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 47.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 2.6 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 83.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

График 10. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 8.

/сая төгрөг/

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	7,438.6	7,438.6	100.0	23,771.4	23,771.4	100.0	1,279.8	1,279.8	100.0
Баян-Өлгий	6,540.4	6,540.4	100.0	29,991.0	29,991.0	100.0	1,028.4	1,028.4	100.0
Баянхонгор	6,979.1	6,979.1	100.0	23,347.2	23,347.2	100.0	1,382.2	1,382.2	100.0
Булган	0.0	0.0	0.0	17,697.6	17,697.6	100.0	1,159.6	1,159.6	100.0
Говьсүмбэр	0.0	0.0	0.0	4,838.2	4,838.2	100.0	785.0	785.0	100.0
Говь-Алтай	5,144.8	5,144.8	100.0	20,026.3	20,026.3	100.0	1,427.9	1,427.9	100.0
Дархан-Уул	0.0	0.0	0.0	21,143.7	21,143.7	100.0	1,202.3	1,202.3	100.0
Дорноговь	0.0	0.0	0.0	16,754.5	16,754.5	100.0	1,639.1	1,639.1	100.0
Дорнод	1,572.9	1,572.9	100.0	18,117.5	18,117.5	100.0	1,377.7	1,377.7	100.0
Дундговь	3,601.6	3,601.6	100.0	13,916.3	13,916.3	100.0	1,245.6	1,245.6	100.0
Завхан	5,891.0	5,891.1	100.0	21,887.8	21,887.8	100.0	1,046.3	1,046.3	100.0
Орхон	0.0	0.0	0.0	18,394.7	18,394.7	100.0	1,301.6	1,301.6	100.0
Өвөрхангай	7,187.3	7,187.3	100.0	28,026.5	28,026.5	100.0	1,483.3	1,483.3	100.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	17,018.1	17,018.1	100.0	2,459.5	2,459.5	100.0
Сүхбаатар	3,202.0	3,202.0	100.0	17,340.8	17,340.8	100.0	928.1	928.1	100.0
Сэлэнгэ	2,250.0	2,250.0	100.0	26,291.2	26,291.2	100.0	1,490.1	1,490.1	100.0
Төв	4,768.0	4,768.0	100.0	26,526.6	26,526.6	100.0	1,168.4	1,168.4	100.0
Увс	6,970.9	6,970.9	100.0	25,218.6	25,218.6	100.0	1,063.3	1,063.3	100.0
Улаанбаатар	0.0	0.0	0.0	189,782.0	189,782.0	100.0	7,293.7	7,293.7	100.0
Ховд	4,863.6	4,863.6	100.0	23,076.0	23,076.0	100.0	1,076.5	1,076.5	100.0
Хөвсгөл	11,242.1	11,242.1	100.0	33,204.3	33,204.3	100.0	1,383.6	1,383.6	100.0
Хэнтий	5,310.9	5,310.9	100.0	21,139.6	21,139.6	100.0	1,327.7	1,327.7	100.0
ДҮН	82,963.2	82,963.2	100.0	637,510.5	637,510.5	100.0	34,549.5	34,549.5	100.0

Эх сурвалж: Сангийн Яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 637.5 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ.

2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр аймгуудын орон нутгийн хөгжлийн санд 34.5 тэрбум төгрөгийг шилжүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнд хүрч биелжээ.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого эхний 7 сарын байдлаар сар бүрийн орлогын төлөвлөгөө давж биелсэн, мөн өмнөх оны мөн үеэс өсөлттэй гарч, төсөвт эерэг нөлөөлөл бий болж байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 1 дүгээр сард 105.3 хувь, 2 дугаар сард 100.0 хувь, 3 дугаар сард 103.1 хувь, 4 сард 104.1 хувь, 5 дугаар сард 103.1 хувь, 6 дугаар сард 103.5 хувь, 7 дугаар сард 108.1 хувийн биелэлттэй гарсан байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс өсөлттэй гарч, тухайлбал: 1 дүгээр сард 31.4 хувь, 2 дугаар сард 35.9 хувь, 3 дугаар сард 37.3 хувь, 4 сард 26.4 хувь, 5 дугаар сард 27.9 хувь, 6 дугаар сард 14.1 хувь, 7 дугаар сард 28.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт ихээхэн нөлөөлсөн. Татварын орлого 2017 он гарснаас хойш сар бүр давж биелэгдсэн байна. Тухайлбал: 2017 оны 1 сард 0.8 хувь байснаа тогтвортой өсч, эхний 7 сарын байдлаар 14.9 хувиар давж биелжээ. Татварын орлогын хувьд онцгой албан татвараас бусад бүх төрлийн татварууд биелэлттэй гарсан.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 1 дүгээр сард 31.6 хувиар давж биелсэн хэдий ч эхний 7 сарын байдлаар 21.0 хувиар дутуу биелсэн байна. Үүнд төсөвт байгууллагын өөрийн орлого, гадаад хандив тусламжийн орлого, газрын тосны орлого болон навигагийн орлого дутуу төвлөрсөн зэрэг нь нөлөөлжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага эхний 7 сарын байдлаар сар бүр дутуу зарцуулагдаж, хэмнэгдсэн байна.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл төлөвлөгөөтэй харьцуулахад 1-7 дугаар сард 21.4-20.2 хувиар дутуу зарцуулагдсан байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ эхний 7 сарын байдлаар 41.4 хувийн гүйцэтгэлтэй гарч байна. Хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл удаашралтай байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА